

Орчны мэдээллийн онолын бүтэц, үндэслэл

Лү Ди

Бээжингийн их сургуулийн Сэтгүүл зүйн сургуулийн профессор, Дуу дүрсний харилцаа судлалын төвийн эрхлэгч, Хятад улс

Цэдэндашийн Заяа 

Бээжингийн их сургуулийн Сэтгүүл зүйн сургуулийн докторант, Бээжин, Хятад

Хүлээн авсан - Received:
2023-11-17

Засварласан - Revised:
2023-11-30

Хэвлэгдсэн - Published:
2023-12-26

enterru88@gmail.com

ORCID: [0009-0009-6735-1212](https://orcid.org/0009-0009-6735-1212)



© 2023, Author(s)

Хураангуй: Амьтай ба амьгүй юмс оршин байгаа л бол түүнийг тойрсон орчны мэдээлэл зайлшгүй агуулагдаж байдаг. Тус онолоор дамжуулан хөрш улс орнууд аливаа нэг салбарт тулгамдаж буй асуудлыг илүү нарийвчлан судлах боломж бүрдэж байна гэж үзсэн. Онолын үндсэн суурь бэхжин тогтож жилээс жилд сонирхон судлах судлаачид нэмэгдэж байгаагийн хувьд орчны мэдээллийн онолын (ОМО) ерөнхий ойлголт, нэгдсэн бүдүүвчийг танилцуулж байна.

Түлхүүр үг: Орчны мэдээллийн онол, хөрш улс, захын бүс нутаг, мэдээлэл

Нэг. Орчны мэдээллийн онолын ерөнхий ойлголт

Орчны мэдээллийн онол гэж чухам юу вэ?⁸ Тус онолын талаар хамгийн нийтлэг ашиглагддаг тодорхойлолт бол “Аливаа бүрэн эрхт тусгаар тогтносон улсын газар нутгийн хоёр тал буюу дотоодын мэдээлэл болон олон улсын мэдээлэл хоёрын дунд нэгдсэн шинж чанартай мэдээлэл дамжих хөдөлгөөнийг орчны мэдээллийн онол гэнэ” (Лү Ди, 2015). Энэхүү тодорхойлолт нь зөвхөн аль нэг улс хоорондын мэдээлэл дамжих талыг тайлбарлаж буй харьцангуй явцуу ойлголт юм. Харин өргөн утгаар нь авч үзвэл нэг бодгаль эсвэл нэг бодгалиас бүрдсэн бүлэг хүрээлэн буй орчноороо дамжуулан бусад бодгаль эсвэл бүлэгт мэдээлэл дамжуулах хөдөлгөөн юм.

⁸ Шинжлэх ухааны онолын хятад хэлэн дэх нэршил 周边传播-周边- орчин, эргэн тойрон хүрээлэн 传播- мэдээлэл, харилцаа холбоо, дамжуулалт гэх үгсийн нийлбэр юм.

Орчны мэдээллийн онол нь зөвхөн дагнасан чиглэлтэй байдаггүй, харин ч зорилго бүхий гадагшаа чиглэл, үнэ цэн бүхий дотоод чиглэл, нэгэн зэрэг хамтад байх хосолмол чиглэл, мөн тархсан олон чиглэлтэй мэдээлэл байна.

Олон улсын нэг чиглэлийн мэдээ нь тодорхой нэг хэмжээ, хэлбэрт хязгаарлагддаг. Энэ нь тухайн улсын мэдээллийн бүрэн эрхт байдлын онцгой байдалд хамаарна. Нэг талын (дамжуулагч, хүлээн авагч талын аль аль нь) ашиг сонирхлыг барьсан мэдээ удаан оршин тогтнохгүй нь гарцаагүй. Учир нь мэдээлэл, энергийн хязгаарлагдмал чанар, системийн тасралтгүй орших зайлшгүй мөчлөгөөс хамаарна.

Орчны мэдээллийн онолын явцуу утгад мэдээ, мэдээлэл болон сэтгүүл зүйн судлалын объект хамаарна. Харин өргөн утгад гараг ертөнц (байгаль, нийгэм) дэх бүх зүйлс (хүн ч бас багтана)-ийн хэлбэр, хувирал болон илрэл орно. Өөрөөр хэлбэл, орчны мэдээллийн онолын ухагдахуунд томдоо гараг эрхэс, багадаа цахилгаан (电子) орно (Лү Ди, 2017).

Органик, органик бус байхаас үл хамааран оршин буй юм бүхэн тодорхой нэг мэдээллийг агуулдаг. Энэ мэдээдэл нь тухайн юмсын хөгжлийн төлөв, явц байдалд ил болон далд хэлбэрээр илэрнэ. Үүнийг тухайн юмсыг хүрээлэн буй орчны субъект болон объект нь хамгийн түрүүнд мэдэрч хариу үйлдэл үзүүлдэг. Тиймээс хоёр эсвэл түүнээс дээш юмс нь хоорондоо харилцан адилгүй байдлаар мэдээлэл дамжуулж, бие биетэйгээ харилцаж, нөлөөлж байдаг. Түмэн зүйлийн мэдээлэл байна гэдэг нь түмэн зүйлийн хүрээлэн буй хязгаар байна гэсэн үг (Лү Ди, 2019). Аливаа юмс (хүн болон хүний нийгэм) маш амархан хүрээлэн буй хязгаарын нөлөөнд ордог, бас хүрээлэн буй хязгаартаа нөлөөлсөөр байдаг.

Үүнээс үзэхэд, орчны мэдээлэл гэдэг ямар баялаг ухагдахуун гэдэг нь харагдана. Орчны мэдээлэл нь хамгийн багадаа гурван давхаргатай. Эдгээр нь: орон зайн орчны мэдээлэл, цаг хугацааны орчны мэдээлэл, харилцааны орчны мэдээлэл. Орон зайн хүрээлэн буй орчин нь мэдээллийг өргөтгөсөн физикийн орон зайгаар нэвтрүүлэхийг хэлнэ. Цаг хугацааны хүрээлэн буй орчин нь цаг хугацаа харилцан үргэлжилж эсвэл давхцлын мэдээлэл үхэх, төрөх үйл явцын хязгаар.

Харилцааны хязгаар бага зэрэг төвөгтэй. Үүнд: Соёл, эдийн засаг, ашиг сонирхол, цэрэг арми, гадаад харилцаа, нийгмийн харилцаа гэх мэт маш олон салбарын орчны мэдээлэл дамжиж байдаг. Харж болдог харилцааны хязгаарт эдийн засаг, соёл, арми орно (Ли Жинвэнь, 2007). Зарим нэг хэсгийг нь харж болдогт гадаад харилцаа, нийгмийн харилцаа багтаж байгаа юм. Хамгийн сүүлд нь, олж илрүүлэхэд хүндрэлтэй ч хаа сайгүй байж байдаг үл үзэгдэх танин мэдэхүйн хязгаар, ашиг сонирхлын хязгаар, удмын, хайр сэтгэлийн хязгаар гэх мэт багтана.

Хоёр. Орчны мэдээллийн онолын философийн үндэслэл

Онолын үүрэг бол тодорхой ойлголт, логикоор дамжуулан хүмүүсийн объектив ертөнцийг системтэй танин мэдэх, илэрхийлэхэд туслах явдал юм. Хүн төрөлхтөнд нэгэнтээ танил болсон нөлөө бүхий онолууд дэвшилтэт шинэлэг санаа агуулахаас гадна гүн гүнзгий философийн учир шалтгааныг агуулж байдаг. Философийн үндэс суурьгүй онол урт хугацаанд оршин тогтнож, түгэн дэлгэрч чадахгүйгээс гадна маш богино хугацаанд хэдэн үзэл санааны амьгүй цуглуулга болж хувирна. Тиймээс философийн учир шалтгаангүй онолыг “онол” гэж нэрлэх тэр дундаа “шинжлэх ухааны онол” гэж нэрийдэхэд тун бэрх.

Орчны мэдээллийн онол нь олон улс, дотоод, бүс нутаг, улс дамнасан соёл зэрэг мэдээллийн төрлүүдтэй тодорхой нэг хэмжээнд холбоо байвч уг онолын үндсэн чанар нь тэс өөр юм. Эл онол нь зөвхөн хэвлэл мэдээлэл биш, ялангуяа явцуу утгатай мэдээний дамжуулалт бүр ч биш юм. Харин түмэн зүйл түмэн бодисын өөрчлөлт, харилцааны мэдээллийн тээвэрлэгч болно. Ингэж үздгийн хувьд улс төр, эдийн засаг, соёл, гадаад харилцаа, цэрэг армийн үйл ажиллагаа нь орчны мэдээллийн онолын өнцгөөс мэдээллийн гол бие, тээвэрлэгч, бас объект ч болж өгдөг (Жан Күн, 2015).

Юмс оршин байгаа л бол түүнийг тойрсон орчны мэдээлэл зайлшгүй байна гэж тус онол үздгийн хувьд хүрээлэн буй орчин нь дараах гурван утгыг агуулна. Нэгт, бодит физикийн орон зай, хийсвэр харилцааны орон зай (нийгэм), хийсвэр болон бодит орон зай хоёрын аль алинд нь байх цаг хугацааны орон зай. Орчлон ертөнц түмэн зүйлийг өөртөө оршоож байдаг шигээ түмэн зүйлс нь бүгд өөрсдийн зах хязгаартай, мөн өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой. Энэхүү уялдаа холбоонд чухал дөрвөн төрлийн хэлбэр хийгээд хэв маяг бий. Үүнд: шууд ба дам, ил ба далд (гадаах болон доторх), хүчтэй ба сул, богино ба урт гэсэн харилцан уялдаатай холбоонууд бий.

Юмс хоорондоо харилцан уялдаатай учир өөрчлөлт байх нь зайлшгүй. Энэхүү уялдаа болон өөрчлөлт нь дүрэмтэй. Байгаль, нийгмийн үзэгдэл шинжлэх ухааны туршилтууд хүний нийгэм болон байгаль ертөнц дээрх өөрчлөлтүүд бүгд нэг “цэг”-ээс эхлэлтэй байдгийг эрдэмтэд хэдийнээ бидэнд нотлон харуулсан. Цэг жижиг эсвэл том байхаас үл хамааран түүнийг “төв” гэж нэрлэнэ. Ингээд аажим аажмаар хүрээгээ тэлж илүү хүчтэй эсвэл дорой болон өөрчлөгдөнө. Энэхүү “төв” нь физик эсвэл цаг хугацааны орон зайн төв биш бөгөөд харин аливаа мэдээллийн үүссэн эсвэл нөлөөлсөн “эхлэл” эсвэл “төгсгөл цэг” болно. Юмсын хүрээлэн буй орчноор дамжин өөр хоорондоо үүссэн нийтлэг уялдаа болон мөнхийн өөрчлөлт нь ертөнцийн түгээмэл зарчим. Тэгвэл энэхүү зарчим нь орчны мэдээллийн онолын философийн үндэс юм.

Юмс хоорондын хамаарал, орчны мэдээлэл дамжуулалтын үзэгдэл, зарчмын талаар хятадын их сэтгэгч нар эртний Тай Жи зураг, түмэн судрын тэргүүн “И Жин”

(易经, дэлхий даяар хамгийн их тархсан “Даогийн сургааль” (道德经) зэрэг судар бичгүүдэд хэдийнээ олж илрүүлэн түүнийг судлан бидэнд үлдээжээ.

Ямар ч мэдээлэл хоосон орон зайд төв эсвэл хүрээлэн буй орчноос хүрээлэн буй орчин руу эсвэл эргээд төв рүүгээ дамжиж байдаг. Дамжих явцдаа аажмаар хүч нэмэгдэх эсвэл багасах төдийгүй ямарч өөрчлөлт орсон энгийнээс илүү төвөгтэй байдал руу шилждэг. Түүний сацуу урт, богино хугацааг туулна. Зах хязгаар болон төв хоёр нь харилцан эсрэгцсэн хүрээ юм. Төвийг дагаад заавал хязгаар байна. Үүнийг эсрэг талаас нь харсан ч яг ижил. Зах хязгаар болон төвийн байрлалын харилцаа нь нэг тогтчихвол дахиж өөрчлөгдөхгүй гэсэн зүйл бас байхгүй. Хэсэг хугацааны хувьсал, аль нэг мэдээллийн үр нөлөөнөөс шалтгаалан өмнө нь зах хязгаар байсан ч шинэ төв болох боломжтой. Тиймээс орчны мэдээллийн онол мэдээлэл судлал, мэдлэгийн онол, арга зүйн онолуудаас ялгаатай.

Гурав. Орчны мэдээллийн онолын загвар

Орчны мэдээллийн онолыг онол арга зүйн боловсрон төлөвшсөн цаг хугацаа талаас нь авч үзвэл хэдхэн жилийн түүхтэй. Харин мэдээллийн түгэлт тархалт, практик талыг нь харгалзах аваас энэхүү онол нь эртнээс эдүгээг хүртэл хүний нийгэм соёл, ялангуяа байгаль нийгмийн үзэгдлүүдэд өргөн цар хүрээтэйгээр өнө урт хугацаанд оршин байсаар ирсэн.

Орчны мэдээллийн онол нь нийгмийн амьдрал дахь олон жишээгээр илэрдгийн нэг нь ДНК юм. Орчин үеийн оюун ухаант хүн 200 гаруй мянган жилийн өмнөөс африк тивээс гаралтай гэдэг. Ойролцоогоор хорин мянган жилээс арван мянган жил хүртэл бидний өвөг дээдс дөрвөн зүг найман зовхист тархаж эхэлжээ. Африкийн дундад өмнө хэсэг, дундад зүүн, газар дундын тэнгисийн эрэг хавь, өмнөд азийн эх газар, дундад ази, зүүн азиас ази, европ тивийн өнцөг булан бүрт хүртэл тархахдаа одоогийн хүний төрхийг олсон юм. Зүүн өмнөд азид ирсэн одоогийн хүн үргэлжлүүлэн зүүн хойд, зүүн өмнөд тийшээ, зүүн хойдод ирсэн нь мөстлөгийн үеийг туулан Берингийн хоолойгоор дамжин хойд америк, өмнөд америк рүү нүүв. Харин зүүн өмнөд рүү тархсан орчин үеийн хүмүүс хэдэн арван мянган жилийг туулан номхон далайн баруун арал, төв номхон далайн арал хүрээд хамгийн сүүлд Австрали тивд хүрч ирсэн. Европын антропологи судлаачид европ хүн европ тивээс үүсэлтэй гэдэг бол ази судлаачид ази хүн ази тивээс тэр дундаа хятад хүнээс үүсэлтэй гэх нь бий. Үүнийг батлах баримтууд ч арвин. Гэхдээ, одоогийн байдлаар африк тивээс орчин үеийн хүн үүссэн гэдэгтэй дийлэнх эрдэмтэд санал нийлдэг (Ралф, 1998: 11-16). Орчин үеийн хүн ази, африк, европ аль ч тивээс үүсэлтэй гэж үзсэн орчны мэдээллийн онолын үзэгдэл хүний үүсэлтэй зэрэгцэн тивээс тив хооронд дамжсаар ирсэн билээ.

Дээр хэсэгт хүн төрөлхтний үүсэл талаас хүрээлэн буй орчны мэдээлэл дамжиж буй арга замыг хөндсөн бол одоо дэлхий дээрх ноёлох гурван том шашныг орчны мэдээллийн онолын үүднээс авч үзвэл илүү тодорхой ойлгогдоно. Дэлхий дээр хамгийн их хүмүүс итгэдэг, хамгийн их нөлөөтэй христийн шашин манай эриний I зуунд Пакистанд үүсэхдээ одоогийнх шиг ийм хүчтэй байгаагүй. Харин нийтийн тооллын 393 онд (380 ч гэдэг) Ромын хаан Теодор нь христийн шашныг улс нийтийн шашин болгон зарлан тунхагласнаас хойш маш хурдтайгаар европын бусад орнууд руу тархсан байдаг. Нийтийн тооллын 500 оны эхнээс эцэс хүртэл христийн шашинт ертөнц бараг тэр чигтээ Ромын эзэнт гүрнийх байжээ (Ралф, 1998: 390, 506). Үүний дараачаар XI-XIII зууныг хамарсан найм дахь загалмайтны аян дайн, XVI зууны барууны колоничлох хөдөлгөөн зэргүүд нь христийн шашныг асар хурдтайгаар америк, ази, далайн тивүүд рүү түгээн дэлгэрүүлсэн. Өөрөөр хэлбэл, барууны эдийн засаг болон нөлөөлөл хүрсэн газар бүрт христийн шашин ул мөрөө үлдээсэн юм. Харин нийтийн тооллын VII зуунд дэлхийн хоёр дахь исламын шашин Саудын Арабын нэгдсэн вант улсын Мекка хотод үүсэн Халифын арми болон арабын наймаачдаар дамжин асар хурдан Арабын хойгийн баруун, зүүн, хойд хэсгүүдэд хүрэв. Зөвхөн Арабын нутгаар тархаад зогсохгүй баруун хойд африкаас Испанийн өмнөд хэсэг, Персийн зүүн хойноос Энэтхэг, зүүн өмнөд ази (Энэтхэг, Индонези) хүртэл хүн, эд таваар, гэх мэт зүйлс буюу өнөөдрийн бидний дэвшүүлж буй орчны мэдээллийн онолын загварын дагуу Исламын шашны гол бүс нутгууд бүрэлдэн бий болжээ. Хүн төрөлхтний гурав дахь том шашин болох буддын шашин нь нийтийн тооллын VI зуунд одоогийн Непалд (хуучнаар эртний Энэтхэгийн харьяаны Капилавасту улс) үүссэн. Маурья улсын хаан Ашокын (нийтийн тооллын өмнөх 273-232) үнэн хүчтэй дэмжлэгтэйгээр буддын шашин нь хоёр урсгалд хуваагдан ойр орчмын улс болон бүс нутаг руу эрчимтэйгээр тархсан. Энэтхэгийн баруун болон зүүн тал тэр чигтээ далайгаар хүрээлэгдсэний улмаас буддын шашны бага хөлгөн нь “Өөртөө эзэн, өөртөө аврагч болох” хэмээх сургаалийг эрхэм болгон Гималайн уул нуруудын бэлийн зүүн хойд хэсэг Мьянмар, Тайланд, Энэтхэг, Хятадын хойг хүртэлх газруудаар тархжээ (Мерфи, 2004: 49-50, 190-191). Буддын шашин нь хүн бүр гэгээрэлд хүрэх боломжтой хэмээн номлодгийнхоо хувьд аливаа биет бурхан шүтээн байхгүй гэж хэлж болно. Тийм ч учраас өмнөх хоёр христ, исламын шашны нэг бурхныг тахин шүтэх үзлээс тэс өөр билээ. Буддын шашны энэхүү үзлээс улбаалан Хятадын Шиньжааны нутагт ислам шашинтнууд хүрч ирэн буддын шашинт нутгийн ард иргэдтэй ямарваа нэг шашны мөргөөлдөөнгүйгээр энх тайван амьдарч байгаа нь үүний тод илрэл. Хятад улсын хувьд күнзийн сургааль нь шууд утгаараа шашны хэв загварт багтдаггүй ч “өөрийн хийхийг хүсэхгүй байгаа зүйлийг бусдад ч бас бүү тулга” хэмээх энэхүү үзэл орчны мэдээллийн онолын зарчмын дагуу эргэн тойрон дахь бага ястан болон хойд солонгосын хойг, япон, вьетнам зэрэг хөрш улсууд руу тархсан.

Орчны мэдээллийн онол дийлэнхдээ эдийн засгаар дамжин тархах нь харьцангуй их. Эртний хотоос авахуулаад одоогийн улс үндэстнүүд үүсэхдээ бүгд л хоосон орон зай болон жижиг овог, отог аймгуудаас үүсэж орчны мэдээллийн онолын тархалтын тусламжтайгаар тасралтгүй өргөжин томорсон байдаг. Эртний Ромын эзэнт гүрэн Ром болон Газар дундын тэнгисийг төв болгон тэлсэн нь орчны мэдээллийн онолын хамгийн сонгодог жишээ юм. Өнөөгийн европын холбоо бол эртний Ромын эзэнт гүрний илүү томорсон л хэлбэр шүү дээ. Европын холбоо хөгжлийнхөө явцад гурван үе шатыг туулсан 1957 оны 6 сард зургаан улсын бүрэлдэхүүнтэй анхны хувилбар, 1967 оны 7 сарын 1-ний өдөр европын хамтын нийгэмлэг, үүний дараачаар 1993 оны 11 сард 27 улсын бүрэлдэхүүнтэй өнөөгийн европын холбоо бий болсон. Хятадын хөх мөрний дагуух 41 хот болон сувдан голын дагуух 9 хот нь мөн л багаас жижиг рүү тэлэн холбоо үүсгэн хөгжиж байна. Хамгийн энгийн жишээ л гэхэд, Бээжин хотын зохион байгуулалт нэгдүгээр тойргоос хоёр, хоёроос гурав, гурваас дөрөв, тав, зургадугаар тойрог хүртэл үргэлжлэн тэлж байгаа нь орчны мэдээллийн онолын багаас жижиг рүү тэлэх хэлбэр юм.

Орчны мэдээллийн онол нь хэл яриа, хувцас, хоол, хөгжим, барилга, баяр ёслол гээд бүхий л зүйлсээр дамжих боломжтой нь тус онолыг баялаг хийгээд судлагдахуун ихтэй болгож байна. Үүн дээр байгалийн шинжлэх ухааны онол судалгааг нэмбэл бүр ч өргөн цар хүрээг хамрах нь ойлгомжтой. Ан амьтдын тархалт, дэлхийн цаг уурын өөрчлөлт, дулааны зөрүү, хүн төрөлхтөн, амьтдын тахлын тархалт зэрэг зүйлс нь орчны мэдээллийн онолын дүрэм зарчимтай шууд холбоотой.

Дөрөв. Орчны мэдээллийн онолын судалгааны систем

Орчны мэдээллийн онол судлалыг мэдлэг, үзэл суртал, үг хэллэг, тохиолдол гэсэн дөрвөн системд хуваан авч үзнэ.

Мэдлэгийн систем нь орчны мэдээллийн онол болон үүнийг судлах судлаачид зайлшгүй байх шаардлагатай мэдлэгийн бүтэц юм. Тус онол нь зөвхөн мэдээ мэдээлэл түгээх зэргээр хязгаарлагдахгүй учир гадаад харилцаа, эдийн засаг, соёл, цэрэг арми, үндэстэн цаашлаад сэтгэлийн хөдөлгөөн гэх мэт олон хэлбэрийг өөртөө агуулна. Өөрөөр хэлбэл орчны мэдээллийн онол нь шинжлэх ухааны салбар алгасаж түүх, газар зүй, олон улс судлал, нийгэм судлал, үндэстэн судлал, шашин, байгалийн шинжлэх ухаан зэрэг бүхий л шинжлэх ухааны суурь мэдлэгийг шаардагдана.

Үзэл суртлын системд өмнөх хэсэгт дурдсан онолын философийн үнэ цэн, мэдлэг болон арга зүйн онол, орчны мэдээллийн онолын гурван үе, дөрвөн загвар, орчны мэдээллийн онолын стратеги болон бодлого хамаарна.

Үг хэллэгийн систем нь дээр дурдсан мэдлэг, үзэл суртлын систем хоёрын гаднах илэрхийлэл юм. Үг хэллэгийн систем нь ойлголт, агуулга, арга, үр дүн хэмээх дөрвөн утгыг агуулна. Орчны мэдээллийн онол нь энгийн мэдээ мэдээлэл түгээх

хэлбэрээс ялгарахын хувьд ойлгоход илүү дөхөм, баялаг илэрхийлэмж, практикийн үнэ цэн, системчлэгдсэн тохирох ай хүрээг шинээр бий болгосон.

Тус онол нь дараах салбар мэдээллүүдэд хуваагдаж байна. Үүнд: хол ойрын зайн, нэг ба хоёр талын мэдээлэл, олон талын мэдээлэл, дотоод хүрээний мэдээлэл, гадаад хүрээний мэдээлэл, бага хүрээний мэдээлэл, том хүрээний мэдээлэл, зөөлөн хүрээний мэдээлэл, хатуу хүрээний мэдээлэл, өөрийн хүрээний мэдээлэл, бусдын хүрээний мэдээлэл, орон зайн хүрээний мэдээлэл, цаг хугацааны хүрээний мэдээлэл, гадагш, дотогш чиглэсэн мэдээлэл, ил ба далд хүрээний мэдээлэл, соёлын хүрээний мэдээлэл, захын орчны соёлын мэдээлэл, эдийн засгийн хүрээний мэдээлэл, захын орчны эдийн засгийн мэдээлэл тархалт, гадаад харилцааны хүрээний мэдээлэл тархалт, захын орчны гадаад харилцааны мэдээлэл тархалт гэх мэт. Дээрх шинээр гарч ирсэн томьёоллууд нь зөвхөн хэвлэл мэдээллийн салбарыг баяжуулаад зогсохгүй олон улсын харилцаа судлал, нийгэм судлал зэрэг шинжлэх ухааны салбаруудын судалгааны объектыг илэрхийлэх, томьёоллыг нэмэгдүүлж байна.

Орчны мэдээллийн онолын сонгодог тохиолдлын систем нь сонголт, цэгцлэх, ангилах зэргүүд нь ухамсартай болон ухамсаргүйгээр ашиглагдсан үр дүнгийн бүтээц байдаг. Нөгөө талаараа энэхүү онолын үндэс нь юм. Тархах агуулгын үүднээс авч үзвэл тус онолын тохиолдлын систем нь хамгийн багадаа мэдээ мэдээллийн орчин дахь тархалтын тохиолдол, соёлын орчинд мэдээлэл тархалтын тохиолдол, эдийн засгийн орчинд мэдээлэл тархалтын тохиолдол, эерэг ба сөрөг орчны мэдээлэл тархалтын тохиолдол гэх мэт орно. Субъект талаасаа хэвлэл мэдээллийн орчин дахь мэдээлэл тархалтын тохиолдол, үндэстэн ястны орчин дахь мэдээлэл тархалтын тохиолдол, улсын орчинд мэдээлэл тархалтын тохиолдол, байгууллагын орчинд мэдээлэл тархалтын тохиолдол, харилцааны орчин дахь мэдээлэл тархалтын тохиолдлууд багтана. Тархах хэлбэр болон суваг талаасаа албан ёсны орчинд мэдээлэл тархах тохиолдол, ард түмний дунд мэдээлэл тархах тохиолдол, бизнесийн хүрээнд мэдээлэл тархах тохиолдол, ураг садны хүрээнд мэдээлэл тархах тохиолдол орно. Тархах чадамжийн хувьд ашигтай орчинд мэдээлэл тархах тохиолдол, сэтгэл хөдлөлийн хүрээнд мэдээлэл тархах тохиолдол, улс төрийн орчинд мэдээлэл тархах тохиолдол багтана. Байгалийн ертөнцөд мэдээлэл тархах тохиолдол энэ хэсэгт төдийлөн чухал биш.

Тав. Орчны мэдээллийн онолын үе шат болон хэлбэр

Орчны мэдээллийн онол нь цэгээс том руу, төвөөс зах руу, ойроос хол руу гэсэн олон давхар тархалт, шилжилтийн үйл явц байдаг. Энэхүү үйл явц нь санамсаргүй эсвэл эмх замбараагүй биш бөгөөд тодорхой дараалал, хэлбэрт оршино.

Орчны мэдээллийн онолын мэдээлэл тархалтын үе шат:

Мэдээлэл болон эрч хүч нь хүрээлэн буй орчины энгийн дүрэм нь физикийн хуулийн дагуу цэгээс цэг рүү, цэгээс тойрог руу, цэгээс том руу гэсэн гурван шатыг туулдаг. Цаг хугацааны хувьд мэдээлэл болон эрч хүч нь хүчирхэгжих, хамгаалагдах, буурах гэсэн гурван шаттай. Мэдээлэл болон эрч хүчний орчны мэдээлэлийн тархалтын зарчим нь онцгой шаталсан, өөрийгөө зохион байгуулсан шинэлэг чанартай байдаг. Энэхүү онцгой чанар нь орчны мэдээллийн онолын судалгааны гол хэсгийн нэг юм. Улс орныг субъектээ болгосон орчны мэдээллийн онол нь орон зай болон цаг хугацаан дээр гурван шатны нэгдлийг илэрхийлж байдаг. Үүнд: зах руу мэдээлэл тархах, зах дотор мэдээлэл тархах, захаас мэдээлэл тархах гэсэн гурван шат багтана. Судлах объектын хувьд юун түүрүүнд хятад улс дахь бага ястнууд, дараа нь хөрш орнууд, үүний дараагаар захын соёл (ислам, христийн шашин болон дэлхийн төлөөлөл болохуйц хэдэн соёлын төрөл) хамаарна. Орчны мэдээлэл тархах агуулгын хувьд нэн тэргүүнд ухамсаргүй үзлийн хэлбэртэй эдийн засгийн мэдээлэл тархалт, үүний дараачаар дорой ухамсартай хэлбэрийн соёлын болон аялал жуулчлалын мэдээлэл тархалт, дараа нь хүчтэй ухамсартай хэлбэрийн улс төр, гадаад харилцаа, цэрэг армийн мэдээлэл тархалт багтана.

Орчны мэдээллийн онолын мэдээлэл тархах 4 загвар:

Орчны мэдээллийн онолын мэдээлэл тархах байдлын хувьд нэг эсвэл түүнээс дээш онолын загвар оруулж болох уу гэвэл болно. Мэдээлэл тархах энэхүү онолын агуулга, хэлбэр нь хэдийгээр олон байгаа ч тэдгээрийг нэгтгэх юм бол дараах 4 загварт хуваагдана.

Нэгт. Төвөөс захруу чиглэсэн загвар. Мэдээлэл эсвэл эрч хүч тухайн улсын (бүс нутаг) улс төр, эдийн засаг, соёлын төвөөс зах хязгаар луу тархана.

Хоёр. Захаас төв рүү чиглэсэн загвар. Мэдээлэл эсвэл эрч хүч тухайн улсын (бүс нутаг) улс төр, эдийн засаг, соёлын захаас төв рүү тархах эсвэл хариу үйлчлэх

Гурав. Захаас зах руу чиглэсэн загвар. Мэдээлэл эсвэл эрч хүч тухайн улстай (бүс нутаг) хил залгаа өөр нэг улс(хоосон орон зай)дахь зах хязгаар луу тархах

Дөрөв. Төвөөс төв рүү чиглэсэн загвар. Мэдээлэл эсвэл эрч хүч тухайн улсын (бүс нутаг) улс төр, эдийн засаг, соёл өөр нэг улсын(бүс нутаг)улс төр, эдийн засаг, соёлын төв рүү шууд тархалт. Энэхүү загвар нь харилцаа холбоо, ачаа тээвэр өндөр хөгжсөн энэ цаг үед маш боломжтой болжээ. Гэхдээ ингэхдээ орчны мэдээллийн онолын үндсэн зарчмыг өөрчилж чадахгүй хэвээр байна. Дээрх 4 загвараас эхний хоёр загвар нь дотоодын орчны мэдээлэлд хамаарах бол, дараагийн хоёр загвар нь олон улсын орчны мэдээлэлд хамаарна.

Зургаа. Орчны мэдээллийн онолын үнэ цэн болон утга учир

Аливаа онолын үнэ цэнийг үзэгдэл тайлбарлах, асуудал шийдвэрлэх, шинийг санаачлах эсвэл шинэ үнэ цэнийг бүтээх гэж товчхон хэлж болно. Тухайн онол судлагдахууны хэрэгсэл болж чадах эсэх нь өөрийгөө баталж чадах, асуудлыг

шийдэж чадах гэсэн хоёр нөхцлөөс шууд хамааралтай. Эхнийх нь эрдэм шинжилгээний ач холбогдолтой бол удаах нь нийгмийн болон хэрэглээний ач холбогдолтой. Орчны мэдээллийн онол нь дээрх шаардлагуудад бүрэн нийцэж байгаагийн хувьд зайлшгүй үргэлжлүүлэн судлах шаардлагатай. Онолын үнэ цэн, ач холбогдлыг онол өөрөө батлах боломжгүй. Хэрвээ аливаа улсын нийслэл нь улсын толгой гэж үзвэл захын бүс нутгууд нь тухайн улсын нүүр болно. Шиньжээнээс Хонг Конг эсвэл Ляо Нин мужийн Дандунаас Хойд солонгосын Синь И жөү, Хар Мөрөнгөөс Оросын Благовешинк рүү харах юм бол хоёр улсын зах хязгаар болсон эдгээр хотуудаас тухайн хоёр улсын нүүр царай, өнгө төрхийг шууд харж болно. Тиймээс захын бүсүүд бол тухайн улсын аюулгүй байдлын баталгаа, нүүр царай бараа бүтээгдэхүүнээр ярьвал гадна сав баглаа боодол болж өгдөг. Нөгөө талаар тухайн улс болон бүс нутгийн байр байдал, хэв загварт шууд нөлөөлдөг. Хятад улсын ерөнхийлөгч Ши Жинь Пин: “Хөрш улсуудад мэдээлэл дамжих байдлыг судалснаар, Хятад улсын цэрэг, гадаад харилцаа, энх тайван, эдийн засаг, соёл, мэдээлэл тархалт бүх талаар сайжирч “мэдээлэл дамжилтын өргөн хүрээ”-г бий болгож буй нь сайшаалтай юм” (“Хөрш орнуудын гадаад харилцаа” симпозиум) гэжээ.

Долоо. Орчны мэдээллийн онолын стратеги бодлого

Хятад Улсын хувьд орчны мэдээллийн онол болон уламжлалт олон улсын хэвлэл мэдээлэл хоорондоо асар зөрүүтэй байгаа нь үнэн. Орчны мэдээллийн онол нь явцуу утгаараа мэдээ мэдээллийн салбарын нэгэн шинэ жижиг хэсэг бөгөөд түүнийг тухайн улс өөрийн болон олон улстай харилцах харилцаанд стратегиа болгон ашиглаж болно. Хятад улсын хувьд Европ, Америкийг чухалчилж хөрш зэргэлдээ улс орнуудаа орхигдуулж байгаа асуудал дээр орчны мэдээллийн онол ажиллах бүрэн боломжтой. Энэхүү онол нь зөвхөн хятад улсын эрх ашгийг хамгаалж, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилготой биш бөгөөд хөрш зэргэлдээ орнуудтай улс төр, эдийн засаг, соёл, нийгэм, ард түмний олон талын харилцааг илүү гүн гүнзгий ойлгон танихад чухал ач холбогдолтой. Аль ч улс орны хувьд хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа хилийн маргаангүй, харилцан ойлголцож сайн хөршийн холбоог байгуулж чадвал олон улсаас ирэх дайралтаас хамгаалж чадна.

Найм. Орчны мэдээллийн онолын хэрэгжиж буй өнөөгийн байдал

Орчны мэдээллийн онол нь эрдэм шинжилгээний салбарт анх дурдагдаад найм орчим жил болж байгаа ч энэхүү хугацаанд нэлээдгүй өргөжин тэлсэн байгаа нь баярлууштай явдал билээ. Бүрэн нэгтгэсэн тоогоор биш ч хятад улс даяар зуу гаруй эрдэмтэн, судлаач, магистр, докторын оюутнууд тус онолын судалгааны багт нэгдэн ороод байна. Үүнийгээ дагаад нийтлэл, судалгаа, дипломын ажлууд хийгдэж эрдэм судлалын уралдаанд нэг, хоёрдугаар байр ч эзэлжээ. Орчны мэдээллийн онол хэмээх нэрийг дурдсан таван төсөл улс, муж, хотуудыг хамран санаачлагдлаа. 2018 оны 4 сар, 2019 оны 9 сар, 2021 оны 4 сард “Хятадын орчны мэдээллийн онол форум” Бээжин,

Нан Нин, Хай Көү гурван хотуудад хуваагдан болов. Тус хурлуудыг Хятадын хэвлэл мэдээллийн төв, Төвийн радио телевиз, Ардын сонин, Синь Хуа агентлаг, Гуан Минь өдрийн сонин, Хай Нин хотын радио телевиз, Гуань Ши радио телевиз, Гуан Дун радио телевиз, Хэй Лун Жяны радио телевиз, Өвөр монголын радио телевиз, Шань Дуны радио телевиз, Төвдийн өдрийн сонин болон захын бүс нутгийн хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд оролцсон өргөн хүрээний форум боллоо. Мөн тус форумд Гуан Мин өдрийн сонин, Хятад радио телевизийн сэтгүүл, орчин үеийн мэдээлэл дамжуулалт, телевиз судлал, мэдээллийн сонирхогч зэрэг сонин сэтгүүлийн нөхөд тус онолын талаар хэлэлцүүлэг өрнүүллээ. Энэхүү онолын өөр нэг томоохон амжилт бол дэлхийд боловсон хүчин бэлтгэх байдлаар эхний хорьт ордог Бээжингийн их сургуулийн хэвлэл мэдээллийн сургуульд тусгайлан энэхүү онолын дагуу анги нээж магистр, докторын оюутнуудыг хамруулах болсон явдал билээ. 2020 оны сүүлээр, Нан Нины багшийн их сургуульд тус судлалын хүрээлэнг мөн албан ёсоор нээн ажиллаж байна. Ийнхүү саяхан эрдэм судлалын салбарт орж ирсэн онол хэдийнээ өөрийн судалгааны баг хамт олон, судлалын хэрэглэгдэхүүн, онолын системээ бүрдүүлж тус онолын дэвшүүлсэн утга учир, ач холбогдлыг тэлсээр буйд туйлын баяртай байна.

Structure and basic of surrounding communication theory

Lu Di

School of Journalism, Beijing University, Beijing, China

Zaya Tsedendash

School of Journalism, Beijing University, Beijing, China

Abstract: As long as animate and inanimate things exist, they inevitably contain information about the surrounding around them. With the help of this theory, it is believed that today neighboring countries have an opportunity to study the problems and questions in any field in more detail. Since the basic theoretical foundation is firmly established and the number of researchers who are interested in studying this is increasing year by year, let us introduce the general concept and integrated scheme of surrounding communication theory.

Keywords: Surrounding communication, neighboring country, peripheral region, information

Ном зүй

Жан Күн, Ч. Я. (2015). Соёлын олон талт байдал ба гадаад харилцааны ялгаатай стратеги. Улаанбаатар.

- Жиньпин, Ш. "Хөрш орнуудын гадаад харилцаа" симпозиум дээр илтгэсэн илтгэл.
[EB/OL].http://www.xinhuanet.com/politics/2013-10/25c_117878897.htm.
- Ли Жинвэнь, Л. Ж. (2007). Соёл ба соёлын үйлдвэрлэл.
- Лү Ди, С. К. (2015). Орчны мэдээллийн онолын ойлголт ба онцлог”. *Орчин үеийн харилцаа холбоо, 3-р улирал*.
- ЛүДи. (2017). Орчны мэдээллийн ойлголт ба дахин эргэцүүлэн бодохуй. *Мэдээний сонирхогч сэтгүүл, 2-р улирал*.
- ЛүДи. (2019). Орчны мэдээллийн онолыг чухалчлан онолын нөлөөг нэмэгдүүлэх. *Хятад улсын радио телевизийн сэтгүүл, 1-р улирал*.
- Мерфи, Л. (2004). *Ази тивийн түүх* (Хуан Линь орчуулга хян.). Хайнан дахь хэвлэл.
- Ралф, Ф. Л. (1998). *Дэлхийн соёлын түүх*. (Фөндөн, Хян.)